



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 06 дугаар сарын 10  
№ 23 /932/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

1543

**Монгол Улсын  
Үндсэн хуулийн  
цэцийн дүгнэлт**

1555

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн  
даргыг томилох тухай**

**Иргэний хэрэг шүүхэд хянан  
шийдвэрлэх тухай хуулийн  
зарим зүйл хүчингүй болсонд  
тооцох тухай, Захиргааны  
хэрэг хянан шийдвэрлэх тухай  
хуульд өөрчлөлт оруулах тухай,  
Эрүүгийн байцаан шийтгэх  
хуульд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн зарим зүйл, заалт  
Үндсэн хуулийн холбогдох  
заалтыг зөрчсөн эсэх маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

|      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 504. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 58 | 1542 |
| 505. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай                      | Дугаар 59 | 1542 |
| 506. | Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай  | Дугаар 60 | 1543 |
| 507. | Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг томилох тухай                         | Дугаар 61 | 1543 |
| 508. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай                       | Дугаар 64 | 1544 |
| 509. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай                | Дугаар 65 | 1544 |
| 510. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 66 | 1545 |
| 511. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай                   | Дугаар 67 | 1550 |
| 512. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 68 | 1554 |
| 513. | Шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, шүүгчийн албан тушаалд томилох тухай    | Дугаар 69 | 1555 |

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

|      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 514. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 08 | 1555 |
|------|--|-----------|------|



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

### Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18, Шүүхийн захиргааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэг, Дамдинсүрэнгийн Дамдин-Од, Дашзэвэгийн Эрдэнэчулуун нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний, Нанзаддоржийн Лүндэндоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

### Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18, Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нанзаддоржийн Лүндэндорж, Дашзэвэгийн Эрдэнэчулуун, Оросоогийн Зандраа, Пүрэвсүрэнгийн Батсайхан нарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

### **Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсонтой холбогдуулан Оросоогийн Зандраагийн Улсын дээд шүүхийн шүүгчийн, Пүрэвсүрэнгийн Батсайханы Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг 2016 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс тус тус түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

### **Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 18, Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нанзаддоржийн Лүндэндоржийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Төгсжаргалын Гандиг эгүүлэн татаж, Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зэнээмядарын Батбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Доржийн Тайванхүү Говь-Алтай, Завхан аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Шадравын Төгсгэрэлийг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас хавсралтад дурдсан хүмүүсийг 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2016 оны 05 дугаар сарын 31-ний  
өдрийн 66 дугаар зарлигийн хавсралт

### **Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх**

1.Лхүндэвийн Наранбаярыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Ядамсүрэнгийн Алтаннавч, Дорждэрэмийн Байгалмаа, Зундуйн Энхцэцэг нарыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2.Гомбын Лхагвамааг Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Хишгээгийн Байгалмаа, Нэргүйн Батчимэг нарыг Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3.Пандийн Долгормааг Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;



Нямдоржийн Насанжаргал, Цогт-Очирын Отгонцэцэг, Шагдаргомбын Төмөрбаатар нарыг Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4.Түндэвийн Даваасүрэнг Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Гомбын Адыяатогтох, Лоолгойн Нямдорж, Готовын Уламбаяр нарыг Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

5.Бадамдоржийн Ариунбаярыг Говь-Алтай, Завхан аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Төмөрпүрэвийн Жаргалсайханыг Говь-Алтай, Завхан аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

6.Оросоогийн Нарангэрэлийг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Солтанмуратын Өмирбек, Нямжавын Туяа нарыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

7.Ёндонгийн Бямбацэрэнг Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Нямаагийн Баярхүү, Төмөрбаатарын Ганбат, Банзрагчийн Оюунцэцэг, Цэвээндээгийн Өрнөндэлгэр, Сампилын Уранчимэг, Маруушийн Хүрэлбаатар нарыг Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

8.Буурайн Баттөрийг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Лувсандашийн Амарсанаа, Гөлгөөгийн Давааренчин, Сүнжидмаагийн Оюунцэцэг, Сосорбарамын Энхжаргал нарыг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

#### **Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх**

1.Арвинбуянгийн Энхбаатарыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;



Одонгийн Баатарсүх, Борын Дэнсмаа, Гун-Аагийн Сүрэн, Базаргарьдын Сүхгомбо нарыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2.Нопын Болормааг Говьсүмбэр, Дорноговь аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Гэндэндоржийн Болормаа, Адилбишийн Сайнтөгс, Гэрэлийн Тэгшсуурь нарыг Говьсүмбэр, Дорноговь аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3.Тогооборын Бямбажавыг Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Халзанхүүгийн Гэрэлмаа, Рашзэвэгийн Мөнх-Эрдэнэ нарыг Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

4.Данзангийн Эрдэнэбилэгийг Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Намсрайн Гачмаа, Магнайбаярын Мөнхдаваа, Сүрэнхорлоогийн Өсөхбаяр нарыг Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

5.Жигдэнгийн Баттогтохыг Говь-Алтай, Завхан аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Батлайн Намхайдорж, Чадраагийн Энхтөр нарыг Говь-Алтай, Завхан аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

6.Дагвын Жамбалсүрэнг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Бэгзийн Дамба, Надмидын Мөнхжаргал, Мөнхбаярын Нямбаяр нарыг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

7.Батчулууны Сосорбарам, Цэдэн-Ишийн Туяа, Сүхээгийн Уранчимэг, Зундуйн Хосбаяр, Сандагийн Цэцэгмаа, Түндэвийн Энхмаа нарыг Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;





8. Батжаргалын Батзоригийг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Цээлийн Амаржаргал, Дагвадоржийн Буянжаргал, Банзайн Манлайбаатар, Ядамсүрэнгийн Туул нарыг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

### **Гурав. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх**

1. Бавалын Баатарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Цэвээндоржийн Алтанцэцэг, Санжаагийн Амардэлгэр, Жагарын Байгалмаа, Ганзоригтын Билгүүн, Содномтүнрэвийн Буд, Дамдинжавын Ганболд, Дашцэрэнгийн Даваасүрэн, Чойндонгийн Даваасүрэн, Алагаагийн Мөнхзул, Намсрайн Нарангэрэл, Намжилсүрэнгийн Оюунтуяа, Бадарчийн Сайханцэцэг, Нарантуяагийн Сарангүн, Дамдинжавын Солонго, Баярсайханы Ундраа, Баатарын Ууганбаяр, Өлзийгийн Уянга, Сэнгээгийн Хишигбат, Батбаярын Цолмонбаатар, Бямбаоугийн Цолмонгэрэл, Жалцангийн Цэнгэл, Цэрэндашийн Цэрэндулам, Сэргэлэнгийн Энхбаяр, Лувсандоржийн Энхжаргал, Төмөртоогоогийн Энхжаргал, Довжилжамцын Энхтуяа, Төмөрсүхийн Энхтуяа, Эрдэнэчимэгийн Энэбиш, Нямдоогийн Баярмаа, Замбалын Баярмаа, Ганболдын Амаржаргалан, Дашдоржийн Золзаяа, Ийгэрийн Амартөгс, Хувсааралын Дашдэчмаа, Дамдингийн Батцэцэг, Бадамдоржийн Мандалбаяр, Довдонгийн Цэрэндолгор, Чимэдцэрэнгийн Ичинхорлоо нарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2. Жамсранжавын Эрдэнэчимэгийг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Равдандоржийн Алтантуяа, Эрдэнэбатын Амин-Эрдэнэ, Бямбаагийн Ариунхишиг, Дагаагийн Байгалмаа, Түмэндэлгэрийн Батсүх, Намдагсүрэнгийн Батчимэг, Мянгаагийн Баясгалан, Тогтохын Гандиймаа, Занын Доржнамжин, Жуумаагийн Кульдана, Доржсүрэнгийн Мөнгөнтуул, Батнасангийн Мөнхжаргал, Чулуунбаатарын Мөнхцэцэг, Дансрангийн Наранцэцэг, Дашцоодолын Нямбазар, Цэрэнпагамын Оюунбилэг, Шонхойн Оюунтуул, Цэдэн-Ишийн Сансармаа, Адъяахүүгийн Сарантуяа, Жигжидсүрэнгийн Сэлэнгэ, Жамъяанчойжилын Сэмжид, Дамдинсүрэнгийн Уранзул, Батсүрэнгийн Хишигбаатар, Дамбадаржаагийн Хулан,



Чулуунбаатарын Цэнд, Дэмчигийн Энхцэцэг, Нэргүйн Хангал, Баяраагийн Баярмаа, Хонгорын Энхзаяа, Багашарын Азбаяр, Даваадоржийн Энхцэцэг, Чулуунбаатарын Нямсүрэн нарыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

**Дөрөв. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх**

1.Мөнхбаярын Алдарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Чойнорын Алтанцэцэг, Содномдаржаагийн Батжаргал, Загдаагийн Болдбаатар, Гомбосүрэнгийн Буяннэмэх, Ийшээгийн Ганбат, Хувьтөгөлдөрийн Идэр, Батбаярын Мөнхбаяр, Баярын Мөнх-Эрдэнэ, Санги-Очирын Олзод, Чулуунбаатарын Отгонбаяр, Самбуугийн Оюунгэрэл, Сүхээгийн Оюунчимэг, Сумъяагийн Пүрэвсүрэн, Барьны Сарантуяа, Үржинбадамын Түмэнжаргал, Боролзойн Халиун, Цолмонгийн Цэлмэг, Төрбатын Шинэбаяр, Нямжавын Баярмаа, Буянтын Дуламсүрэн, Энхтайвангийн Чингис нарыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

2.Ёндонгийн Цогтзанданг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

Довчинсэнгээгийн Алтанжигүүр, Түмэн-Өлзийгийн Алтантуяа, Амаржаргалын Алтанхуяг, Гаанжуурын Алтанцэцэг, Лхамхүүгийн Баатар, Сайнбаярын Базарханд, Бадамрагчаагийн Батболор, Сэлэнгийн Батгэрэл, Дэндэвийн Батсуурь, Гомбодоржийн Ганбаатар, Лувсандашийн Гансүх, Цэгмидийн Дайрийжав, Банзрагчийн Дашдондов, Гансүхийн Есөн-Эрдэнэ, Осордэлэгийн Жанчивнямбуу, Намжилдоржийн Мөнхбаяр, Гантөмөрийн Мөнхзул, Хашхүүгийн Одбаяр, Лхам-Янжингийн Оюун, Цэвэгдоржийн Оюунчимэг, Лханаажавын Оюунчимэг, Пагамын Туяат, Баяраагийн Батаа, Цэнд-Очирын Мөнх-Эрдэнэ нарыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас;

3.Нямдоржийн Одонтуулыг Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас;

**Тав. Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх**

1.Дүйсенбекийн Көбөшийг Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас.



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 67

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5, Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд хавсралтад дурдсан хүмүүсийг 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2016 оны 05 дугаар сарын 31-ний  
өдрийн 67 дугаар зарлигийн хавсралт

### **Нэг. Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх**

1.Түндэвийн Даваасүрэн, Лоолгойн Нямдорж нарыг Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

2.Дүйсенбекийн Көбөш, Солтанмуратын Өмирбек нарыг Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

3.Магнайбаярын Мөнхдаваа, Готовын Уламбаяр нарыг Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

4.Ёндонгийн Бямбацэрэн, Сүхээгийн Уранчимэг, Маруушийн Хүрэлбаатар нарыг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

5.Төмөрпүрэвийн Жаргалсайхан, Чадраагийн Энхтөр нарыг Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;



6.Хишгээгийн Байгалмаа, Гомбын Лхагвамаа, Гэрэлийн Тэгшсуурь нарыг Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

7.Цээлийн Амаржаргал, Банзайн Манлайбаатар, Ядамсүрэнгийн Туул нарыг Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

8.Лувсандашийн Амарсанаа, Оросоогийн Нарангэрэл, Сүнжидмаагийн Оюунцэцэг, Сосорбарамын Энхжаргал нарыг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

9.Нэргүйн Батчимэг, Нопын Болормаа, Адилбишийн Сайнтөгс нарыг Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

10.Лхүндэвийн Наранбаяр, Арвинбуянгийн Энхбаатар, Зундуйн Энхцэцэг нарыг Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

11.Тогооборын Бямбажав, Рашзэвэгийн Мөнх-Эрдэнэ, Цогт-Очирын Отгонцэцэг нарыг Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

12. Бадамдоржийн Ариунбаяр, Жигдэнгийн Баттогтох, Батлайн Намхайдорж нарыг Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

13.Цэдэн-Ишийн Туяа, Зундуйн Хосбаяр, Сандагийн Цэцэгмаа нарыг Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

14.Буурайн Баттөр, Банзрагчийн Оюунцэцэг, Сампилын Уранчимэг нарыг Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

15.Халзанхүүгийн Гэрэлмаа, Пандийн Долгормаа, Нямдоржийн Насанжаргал нарыг Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

16.Гомбын Адьяатогтох, Намсрайн Гачмаа, Данзангийн Эрдэнэбилэг нарыг Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

17.Одонгийн Баатарсүх, Дорждэрэмийн Байгалмаа, Гун-Аагийн Сүрэн нарыг Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;



18.Батжаргалын Батзориг, Дагвадоржийн Буянжаргал, Гөлгөөгийн Давааренчин нарыг Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

19.Гэндэндоржийн Болормаа, Цэвээндөөгийн Өрнөндэлгэр, Шагдаргомбын Төмөрбаатар, Түндэвийн Энхмаа нарыг Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

20.Дагвын Жамбалсүрэн, Надмидын Мөнхжаргал нарыг Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

21.Бэгзийн Дамба, Мөнхбаярын Нямбаяр, Нямжавын Туяа нарыг Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

22.Нямаагийн Баярхүү, Төмөрбаатарын Ганбат, Батчулууны Сосорбарам нарыг Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

23.Ядамсүрэнгийн Алтаннавч, Борын Дэнсмаа, Базаргарьдын Сүхгомбо нарыг Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

#### **Хоёр. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх**

1.Санжаагийн Амардэлгэр, Ганболдын Амаржаргалан, Дамдингийн Батцэцэг, Замбалын Баярмаа, Дамдинжавын Ганболд, Дашдоржийн Золзаяа, Бадамдоржийн Мандалбаяр, Алагаагийн Мөнхзул, Нарантуяагийн Сарангун, Баярсайханы Ундраа, Бямбаюугийн Цолмонгэрэл, Довдонгийн Цэрэндолгор, Цэрэндашийн Цэрэндулам, Лувсандоржийн Энхжаргал, Төмөртоогогийн Энхжаргал, Эрдэнэчимэгийн Энэбиш нарыг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

2.Бавалын Баатар, Ганзоригтын Билгүүн, Дашцэрэнгийн Даваасүрэн, Чимэдцэрэнгийн Ичинхорлоо, Дашцоодолын Нямбазар, Намжилсүрэнгийн Оюунтуяа, Бадарчийн Сайханцэцэг, Дамдинжавын Солонго, Баатарын Ууганбаяр, Өлзийгийн Уянга, Сэнгээгийн Хишигбат, Сэргэлэнгийн Энхбаяр нарыг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

3.Цэвээндоржийн Алтанцэцэг, Ийгэрийн Амартөгс, Жагарын Байгалмаа, Нямдоогийн Баярмаа, Содномтүнрэвийн Буд, Чойндонгийн Даваасүрэн, Хувсааралын Дашдэчмаа, Намсрайн Нарангэрэл, Жалцангийн Цэнгэл, Довжилжамцын Энхтуяа, Төмөрсүхийн Энхтуяа нарыг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;



4.Багашарын Азбаяр, Равдандоржийн Алтантуяа, Мянгаагийн Баясгалан, Тогтохын Гандиймаа, Занын Доржнамжин, Жуумаагийн Кульдана, Чулуунбаатарын Мөнхцэцэг, Дансрангийн Наранцэцэг, Шонхойн Оюунтуул, Адъяахүүгийн Сарантуяа, Нэргүйн Хангал, Чулуунбаатарын Цэнд, Хонгорын Энхзаяа нарыг Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

5.Бямбаагийн Ариунхишиг, Дагаагийн Байгалмаа, Доржсүрэнгийн Мөнгөнтуул, Батнасангийн Мөнхжаргал, Цэрэнпагамын Оюунбилэг, Цэдэн-Ишийн Сансармаа, Дамбадаржаагийн Хулан, Даваадоржийн Энхцэцэг, Дэмчигийн Энхцэцэг, Жамсранжавын Эрдэнэчимэг нарыг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

6.Эрдэнэбатын Амин-Эрдэнэ, Түмэндэлгэрийн Батсүх, Намдагсүрэнгийн Батчимэг, Баяраагийн Баярмаа, Жигжидийн Лхагвасүрэн, Чулуунбаатарын Нямсүрэн, Хаянхярваагийн Оюунжаргал, Самбуугийн Оюунчимэг, Жигжидсүрэнгийн Сэлэнгэ, Жамъяанчойжилын Сэмжид, Дамдинсүрэнгийн Уранзул, Батсүрэнгийн Хишигбаатар, Батбаярын Цолмонбаатар нарыг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

#### **Гурав. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх**

1.Чойнорын Алтанцэцэг, Дэндэвийн Батсуурь, Дагвадоржийн Мөнхтуяа, Нямдоржийн Одонтуул, Самбуугийн Оюунгэрэл, Сүрэнхорлоогийн Өсөхбаяр, Сумъяагийн Пүрэвсүрэн, Барьны Сарантуяа, Энхтайвангийн Чингис, Төрбатын Шинэбаяр нарыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

2.МөнхбаярынАлдар, ЗагдаагийнБолдбаатар, БуянтынДуламсүрэн, Хувьтөгөлдөрийн Идэр, Баярын Мөнх-Эрдэнэ, Сүхээгийн Оюунчимэг, Үржинбадамын Түмэнжаргал нарыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

3.Сэлэнгийн Батгэрэл, Содномдаржаагийн Батжаргал, Нямжавын Баярмаа, Гомбосүрэнгийн Буяннэмэх, Батбаярын Мөнхбаяр, Борлозойн Халиун, Ёндонгийн Цогтзандан нарыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

4.Амаржаргалын Алтанхуяг, Цэгмидийн Дайрийжав, Гансүхийн Есөн-Эрдэнэ, Осордэлэгийн Жанчивнямбуу, Цэнд-Очирын Мөнх-Эрдэнэ, Чулуунбаатарын Отгонбаяр, Лхам-Янжингийн Оюун, Лханаажавын



Оюунчимэг нарыг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

5.Довчинсэнгээгийн Алтанжигүүр, Сайнбаярын Базарханд, Бадамрагчаагийн Батболор, Намжилдоржийн Мөнхбаяр, Хашхүүгийн Одбаяр, Санги-Очирын Олзод, Пагамын Туяат нарыг Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

6.ГаанжуурынАлтанцэцэг, Түмэн-ӨлзийгийнАлтантуяа,Лхамхүүгийн Баатар, Баяраагийн Батаа, Гомбодоржийн Ганбаатар, Ийшээгийн Ганбат, Лувсандашийн Гансүх, Банзрагчийн Дашдондов, Гантөмөрийн Мөнхзүл, Цэвэгдоржийн Оюунчимэг нарыг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд;

7.Цолмонгийн Цэлмэгийг Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Хаянхярваагийн Оюунжаргалыг Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Жигжидийн Лхагвасүрэнг Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Самбуугийн Оюунчимэгийг Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дагвадоржийн Мөнхтуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 05 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Дамдинсүрэнгийн Дамдин-Од, Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэг нарын шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, Дамдинсүрэнгийн Дамдин-Одыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэгийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 06 дугаар  
сарын 08-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай,  
Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 14.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Солонго, Д.Ганзориг нарын





бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаар оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Г.Болорцэцэг, К.Жархынбек, Н.Мөнгөнтуяа, Б.Номин болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцов.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалт, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд оршин суугч, иргэн Г.Болорцэцэг Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн мэдээлэлдээ:**

“Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэж, мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн “172-178 дугаар зүйлд” гэснийг “172-176 дугаар зүйлд” гэж өөрчилсүгэй.” гэж, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: ... 347.1. Хяналтын журмаар хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэж тус тус заасан байна.

Ийнхүү заасан нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Улсын дээд шүүх хяналтын журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хуульд харшилсан шийдвэр гаргавал шийдвэрээ дахин хянах боломжийг бий болгох, шүүх ямар ч тохиолдолд алдаагүй шийдвэр гаргах ёстой гэсэн үзэл баримтлалыг илэрхийлсэн Үндсэн хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан” гэсэн 176<sup>1</sup> дугаар зүйлийг нэмж, 176<sup>1</sup> дугаар зүйлийн 176<sup>1.1</sup> дэх хэсэгт “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 176.2-т заасан тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.” гэж, 176<sup>1.2</sup> дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 174.1-д заасан хугацаанд дүгнэлт гаргаж, уг хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. ...” гэж нарийвчлан зохицуулж өгсөн. Энэ зохицуулалт нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зохих тусгалаа олсон.

Гэтэл Улсын Их Хурал нь хяналтын шатны шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдсон зохицуулалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас хассанаар Улсын дээд шүүх өөрийн хууль зөрчсөн шийдвэрийг өөрөө хүчингүй болгох эрх зүйн үндэслэлгүй болгож, Үндсэн хуулийг ноцтой зөрчиж байна.

Түүнээс гадна Үндсэн хуулийн цэц нь 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар дүгнэлт, 2015 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 05 дугаар тогтоолоороо Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянаад “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна ...” гэж хуульчилсан нь Улсын дээд шүүх хуульд харшилсан шийдвэр гаргасан бол тухайн шийдвэрийг Улсын дээд шүүх өөрөө хянаж, хүчингүй болгох эрхийг хязгаарласан шинжтэй байх тул Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна гэж үзэн, уг хуулийн заалтыг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.



Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол гарсан байтал Улсын Их Хурал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар “Хяналтын шатны шүүхийн тогтоолд гомдол, эсэргүүцэл гаргаж дахин хянуулах боломжийг хааж, агуулгын хувьд хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байх”-аар зохицуулсан нь Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтыг зөрчиж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэж заасныг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

**Хоёр. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд оршин суугч, иргэн Л.Лхаасүрэн, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд оршин суугч, иргэн Б.Номин, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн К.Жархынбек нар Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:**

“... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулиар уг хуулийн 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгосон байх бөгөөд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй байсныг мөн хүчингүй болгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлд мөн өөрчлөлт оруулсан байна. Ингэснээр хэргийн зохигч, Улсын ерөнхий прокурор нь Улсын дээд шүүхийн тогтоол хууль зөрчсөн гэж үзвэл гомдол гарган, Улсын дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаараа хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ хууль зөрчсөн, хуулийг буруу хэрэглэсэн эсэхээ эргэж харах боломж бүрддэг байсныг хүчингүй болгосон байна.

1. Улсын ерөнхий прокурор, хэргийн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн зүгээс Улсын дээд шүүхийн

тогтоол нь хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр гаргасан гомдлыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт гаргаж, уг хэргийг нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлдэг байсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан иргэний эрхийг баталгаажуулж байсан юм.

Гэтэл Улсын дээд шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхийг хязгаарласан явдал нь иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн нөхцөл байдлыг бий болгоод байна.

Улсын дээд шүүх нь нийт шүүгчдийн хуралдаанаар 2014 онд нийт 208 хэрэг, 2015 онд нийт 248 хэргийг тус тус хянасан болохоо тайландаа дурдсан байх бөгөөд Ерөнхий шүүгчийн зүгээс гомдлыг хүлээн авах хууль зүйн үндэслэл байгаа гэж үзсэний үндсэн дээр ийнхүү хянаж байгааг тодотгох нь зүйтэй байна. Нөгөө талаас 2014 онд 208 иргэн, 2015 онд 248 иргэний Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдөж болох байсан нь харагдаж байна.

2. Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын шийдвэрийг хүчингүй болгох эсэхээ хэргийн зохигчоос ирүүлсэн гомдол, эсхүл Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр нийт шүүгчдийн хуралдаанаараа хянан хэлэлцдэг бөгөөд Улсын дээд шүүхийн гомдол болон эсэргүүцлийн дагуу хянан шалгах эрхийг хязгаарласан явдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь заалтад заасан Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байх гэж заасныг зөрчиж байна.

Тодруулбал, Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ гэж заасан бөгөөд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон 24 шүүгчийн бүрэлдэхүүнээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр гэж үзэхээр байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн болохыг тогтоож, эдгээр хуулиудыг хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.



**Гурав. Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хороонд оршин суугч, иргэн Н.Мөнгөнтуяа Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:**

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэж заасан. Энэ нь Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх боловч уг шийдвэр хуульд харшилсан буюу хууль ёсны байх шаардлагыг хангаагүй байвал Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох тухай агуулгыг шууд утгаар, эргэлзээгүйгээр зохицуулжээ.

Улсын дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эрх хэмжээ гагцхүү Улсын дээд шүүхэд өөрт нь ийнхүү Үндсэн хуулиар олгогдсон байна. Энэ нь нэг талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн ...” гэсэнтэй нийцэж байгаа юм. Гэхдээ аливаа эрх зүйн маргаан, гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн шийдвэр нь шүүхийн эцсийн шийдвэр байх боловч хууль ёсны болон үндэслэл бүхий байх шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд уг шаардлагыг хангаснаар түүнийг иргэн, албан тушаалтан хэн ч заавал биелүүлэх үүрэгтэй гэх зарчим эргэлзээгүйгээр хэрэгжих юм.

Ийм учраас хуульд харшилсан шийдвэрээ Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох агуулга бүхий заалт Үндсэн хуульд тусгагджээ. Энэ нь Улсын дээд шүүхийн шийдвэрийг хэн ч хянахгүй, хянах арга журам байхгүй учраас тодорхой хувийн ашиг сонирхлын үүднээс хууль зөрчсөн шийдвэрийг гарган, шударга ёс, эрх зүйн ухамсрыг умартахгаас сэргийлж, Улсын дээд шүүхийн шийдвэр тодорхой хяналттай байх нөхцөлийг бий болгосон юм.

Гэтэл иргэний болон захиргааны эрх зүйн маргаан, гэмт хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоол хууль зөрчсөн тохиолдолд зохигчид, шүүгдэгч, хохирогч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч Ерөнхий шүүгчид гомдол гаргах, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих, Ерөнхий шүүгч гомдлыг урьдчилан хянан үзээд, үндэслэлтэй гэж үзвэл Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн



хуралдаанаар хэлэлцүүлэх тухай дүгнэлт гаргах, уг дүгнэлтийн дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчид хэргийг хянан шийдвэрлэх журмыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлийг хүчингүй болгож, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 347.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах байдлаар хүчингүй болгосон нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно." гэсэн хэсгийг практикт хэрэгжих боломжгүй болгосон, хууль дээдлэх зарчмыг хөндсөн байна.

Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэн баталсан 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187 дугаар зүйлийн 187.1-д "Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тогтоол нь эцсийн шийдвэр болно. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоол хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч түүнд нэг удаа эсэргүүцэл бичиж хэлэлцүүлэх эрхтэй" гэсэн заалт мөн тусгагдсан байжээ.

Иймд 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл, мөн өдрийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлүүд нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно." гэсэн заалтыг зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү." гэжээ.

**Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:**

"... Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3, 6 дугаар дүгнэлтүүд, 5, 7 дугаар тогтоолуудыг гаргахдаа Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргахгүй, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэрэг, маргааныг хянан



шийдвэрлэх асуудлыг хэлэлцэхгүй гэж үзэж Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, 17.2 дахь хэсгийн холбогдох заалтыг хүчингүй болгосонтой нийцүүлж Улсын Их Хурал хуулиудыг баталсан. Үүнд:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүгчдийн бүрэлдэхүүнтэй холбогдсон заалтыг хэвээр үлдээж, хяналтын шатны шүүхийн тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдсон зохицуулалтыг хассан.

Түүнчлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаантай холбогдсон 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлүүдийг хүчингүй болсонд тооцсон.” гэжээ.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулиудад хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоол хууль зөрчсөн, хуульд харшилсан бол Улсын дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаараа хянаж эцэслэн шийдвэрлэхтэй холбоотой журмыг зохицуулсан зүйл, заалтыг хүчингүй болгож, өөрчлөн найруулсан байна. Дээрх хуулиуд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэсэн заалтыг хэрхэн хэрэгжүүлэх, хуульд харшилсан шийдвэрээ ямар журмаар хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулалтгүй орхиж, хуулийн хийдэл бий болгожээ. Гэвч энэ нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байх бөгөөд Улсын Их Хурал хууль батлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд дээрх хийдлийг арилгах боломжтой юм.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн

“... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэсэн заалтыг зөрчсөн гэж эцэслэн шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар тогтоол хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн холбогдох хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын холбогдох хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалт, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176<sup>1</sup>, 177, 178 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.”; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн “172-178 дугаар зүйлд” гэснийг “172-176 дугаар зүйлд” гэж өөрчилсүгэй.”; Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “... 347.1.Хяналтын журмаар хэргийг 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх





бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**П.ОЧИРБАТ**

**ГИШҮҮД**

**Ш.ЦОГТОО**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.СОЛОНГО**

**Д.ГАНЗОРИГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medelel@parliament.mn](mailto:turiin_medelel@parliament.mn)

**Утас: 262420**

Хэвлэлийн хуудас: 1,5

**Индекс: 14003**